



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/441

Мандалговь

Аймгийн "Шилдэг багш" шалгаруулж,
урамшуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4, аймгийн Засаг даргын 2017 оны А/407 дугаар захирамжаар батлагдсан "Шилдэг төрийн албан хаагч шалгаруулж, урамшуулах журам"-ын 4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2018 оны аймгийн "Шилдэг багш"-аар нэр бүхий 6 багшийг журмын дагуу шалгаруулж тус бүр өргөмжлөл, 1000000 төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шилдэг багшаар шалгарсан багш нарын нэрсийг 1 дүгээр, урамшууллын зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Шагналын зардалд шаардагдах 6.291.000 (зургаан сая хоёр зуун ерэн нэгэн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГазар (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010378

Аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар
сарын 09-ний өдрийн 441 тоот
захирамжийн 1 дүгээр хавсралт

Шилдэг багшаар шалгарсан багш нарын нэрс

№	Овог нэр	Албан тушаал
1	Амаржаргал Уранчимэг	"Эрдмийн далай" цогцолбор сургууль, физик багш
2	Баасанжав Мөнхзаяа	"Мандал" сургууль бага ангийн багш
3	Д.Мөнхцэцэг	5 дугаар цэцэрлэгийн багш
4	Ганбат Оюунгэрэл	"Мандал" сургууль бага ангийн багш
5	Дашзэвгэ Отгонсүрэн	"Хүмүүнлэг" сургууль монгол хэлний багш
6	Төмөрбат Эрдэнэсүх	"Эрдмийн далай" цогцолбор сургууль, бие тамирын багш

Аймгийн Засаг даргын 2018 оны
10 дугаар сарын 09-ний өдрийн ~~144~~ тоот
Захирамжийн 2 дугаар хавсралт



Шилдэг багш урамшуулах, урамшууллын зардал

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Урамшуулал	6	1000000	6000000
2	Өргөмжлөл	6	42000	252000
3	Батламж	6	6500	39000
	ДҮН			6291000